

Монгол улсын 2003 оны Хүний Хөгжлийн Илтгэлийн зохион байгуулагч багаар Монголын Хүн ам ба Хөгжил Нийгэмлэг ажиллаж байна.

Монгол Улсын 2003 оны Хүний Хөгжлийн Илтгэл нь “Хот ба Хөдөө дэх Хүний Хөгжлийн ялгаатай байдал “сэдэвтэй бэлтгэгдэж байгаа бөгөөд энэ ажлын хүрээнд 3 насны бүлгээр эссе, зохион бичлэг болон гар зургийн уралдааныг зарласан юм. Оюутан залуусын дунд зарласан Эссе бичих уралдаанд өөрсдийн авъяас мэдлэг оюун ухаанаар шалгаран 1-р байр эзэлсэн 2 бүтээлийг та бүхэнд толилуулж байна.

ИРГЭНИЙ ОРОЛЦОО БА ХОТ, ХӨДӨӨ ДЭХ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ЦЛГАА

Б.НАРАНТУЯА, МУИС-ийн Хууль Зүйн Дээд Сургуулийн оюутан

1990-ээд оноос эхэлсэн ардчилсан өөрчлөн байгуулалт нь Монголчуудын эвлэлдэн нэгдэх, үг хэлэх эрх чөлөөг эрхэмлэн үздэгийн баталгаа болсон ТББ болон сайн дурын бусад байгууллагыг олноор төрөн гаргахад хүргэсэн билээ. Иргэний нийгэм гэдэг ойлголт нь Засгийн газрын үйл ажиллагаа оролцооноос шууд хамааралгүйгээр тухайн нийгмийн гишүүд өөр хоорондоо болон нийгмийн хөгжлийн төлөө хамтран ажиллах бүх хэлбэрийг агуулж байдаг.

Бүр тодруулбал, энэхүү ухагдахууны хүрээнд тухайн иргэн өөрийн хүсэл эрмэлзлэлийн дагуу янз бүрийн сонирхолын бүлэг, холбоодод гишүүнээр элсэн орж, зохион байгуулалтын ардчилсан бөгөөд олон ургальч хэлбэрийн үйл ажиллагаанд эрх тэгш оролцох асуудал багтана.

1990 оны “Улс төрийн намуудын тухай хууль”-иар иргэдийн улс төрийн нам байгуулах, үйл ажиллагаанд хамрагдах болон бусад зохицуулалтыг бий болгосон юм.

Монгол улсад өнөөгийн байдлаар албан ёсоор бүртгэгдсэн улс төрийн 18 нам үйл ажиллагаагаа

явуулж байна. 1997 онд батлагдсан “Төрийн бус байгууллагын тухай хууль” болон бусад 80 гаруй хуулийн зохих заалтаар иргэнд ТББ байгуулах замаар эвлэлдэн нэгдэх эрхээ эдэлж байгаа бөгөөд 2002 оны байдлаар улсын хэмжээнд 2200 гаруй ТББ улсын бүртгэлд бүртгэгджээ. Түүнчлэн мэргэжил, үйлдвэрлэлийн чиглэлээр 105.3 мянган гишүүнтэй Үйлдвэрчний эвлэлүүдийн 12 холбоо, анхан шатны 2300 байгууллагад 220.0 мянга гаруй гишүүн хамрагддаг. / Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай илтгэлээс 2002 он/

10-аад жилийн өмнөхтэй харьцуулахад иргэдийн иргэний нийгмийн институтуудын, тэр дундаа ТББ-ын үйл ажиллагааг сонирхох, хамрагдах эрмэлзэл харьцангуй өссөн. Энэ нь нэг талаас ТББ-уудын явуулж буй үйл ажиллагааны үр дүн, нөгөө талаас иргэдийн нийгмийн амьдралд оролцох, мэдээлэл олж авах, өөрийгөө хөгжүүлэх сонирхол нэмэгдсэнтэй холбоотой гэж үзэж болно.

Харамсалтай нь ихэнх байгууллагууд Улаанбаатар хотод төвлөрч үйл ажиллагаагаа явуулдагаас хөдөөгийн иргэд өөрийн сонирхсон, хэрэгцээтэй салбарын ТББ-ын үйл ажиллагаанд хамрагдах боломжийг тэр бүр олгодоггүй. Энэ ч утгаараа хөдөөд иргэний нийгмийн байгууллагуудыг мэдрэх мэдрэмж, эрэлт, хэрэгцээ хотынхтой харьцуулбал бага байна.

Гэхдээ зарим томоохон жишээлбэл, Улаан загалмай нийгэмлэг, Монголын залуучуудын холбоо, Монголын эмэгтэйчүүдийн холбоо, Скаутын холбоо, Либериаал эмэгтэйчүүдийн оюуны сан, Хүүхдийн төлөө Үндэсний төв гэх мэт байгууллагууд үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгааг тэмдэглэх хэрэгтэй.

Түүнчлэн шинээр үүссэн ч тодорхой хэмжээний чадварлаг, нэр хүнд нь өсч яваа зарим ТББ орон нутагт өөрийн салбарыг байгуулах, хөдөөд хүрч ажиллахыг эрмэлзэх болсон нь сайшаалтай.

Жендэр ба хот, хөдөөгийн хүний хөгжлийн ялгаа

Монгол Улс эмэгтэйчүүдийн “Иргэний болон Улс төрийн Эрхийн Пакт” , “Эдийн засаг, Нийгэм, Соёлын Эрхийн Акт” болон “Эмэгтэйчүүдийг Ялгаварлан Гадуурхах Бүх Хэлбэрийг Устгах тухай Конвенц” зэрэг олон улсын олон талт 29 гэрээнд нэгдэн орсон. Мөн Кайрын “Хүн ам ба хөгжил “ дэлхийн бага хурал /1994/, Копенгагены Нийгмийн асуудлаарх дэлхийн дээд хэмжээний уулзалт /1995/, Бээжингийн Дэлхийн Эмэгтэйчүүдийн бага хурал /1995/ зэрэг олон улсын томоохон арга хэмжээнд оролцож, 1992 оны “Хөдөөгийн Эмэгтэйчүүдийн Байдлыг Сайжруулах Тунхаглал”-ын үзэл санааг хүлээн зөвшөөрсөн юм. Энэ нь эрэгтэй, эмэгтэйчүүдийн эрх тэгш хүртээмжийг боловсрол, ажил эрхлэлт, эрүүл мэндийн болон нийгмийн салбарт нэвтрүүлэхэд чиглэгдсэн 1996-2020 оны хооронд 10 салбарт /1999 онд Эмэгтэйчүүд ба хүрээлэн буй орчин гэсэн 11 дэх салбар нэмэгдсэн/ хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр юм.

Харамсалтай нь хөтөлбөрийн хэрэгжилт удаан, зорилго нь тэр бүр биелэгдэхгүй байна. Жендэрийг ойлгох иргэдийн ойлголт янз бүр байна. 5 жилийн өмнөхтэй харьцуулахад хот суурин газрынхны жендерийн асуудалд хандах хандлага нэлээд нааштай болсон боловч уламжлалт “эмэгтэй хүн ухаан богинотойн” ойлголт ялангуяа хөдөөд гүн бат хэвээр байгаа гэж хэлж болно.

Жендэрийн асуудал өнөөг хүртэл хүссэн үр дүнд хүрэхгүй байгаад эмэгтэйчүүдийн өөрсдийнх нь бодол, ойлголт нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл, дийлэнх Монгол эмэгтэйчүүдийн дунд эрчүүдийн давуу талыг ямар нэг хэмжээгээр хүлээн зөвшөөрсөн, өнөөгийн байгаа байдалдаа ханасан сэтгэл зүйн орчин бүрэлдээд байна. Тэр бүү хэл зарим нь жендэрийн талаар ярьсан хүн, үйл ажиллагаа явуулдаг байгууллагад төдийлөн таатай биш хандах хандлага илэрдэг. /Жендэр гэдэг үгийг хүйсийн тэгш эрх биш зөвхөн эмэгтэйчүүдийн эрх мэтээр ойлгодог учраас эрх мэдэлд дурлагч эмэгтэйчүүдийн бүлэглэл гэж үзэх нь бий./

Жендэрийн асуудал Монгол улсын хүн амын тодорхой хувийг бүрдүүлдэг казак иргэдийн хувьд нэлээд хурцаар тавигдаж байгаа юм. Казак эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах хууль зүйн дорвитой баримт бичиг өнөөг хүртэл боловсруулагдаагүй, энэ талаар үйл ажиллагаа явуулдаг байгууллага

байдаггүйгээс хүйсийн тэгш эрх Баян-Өлгий , Увс аймгийн захын сумдад ноцтой зөрчигддөг.

Жендэрийн асуудалд шинээр гарч буй нэг зүйл бол боловсрол дахь жендэр юм. Иргэд амьжиргааны дорой байдлаасаа болж “алс ирээдүйг нь бодолцон “ эмэгтэй хүүхдээ номын мөр хөөлгөх үзэгдэл хөдөөд түгээмэл байдаг. Энэ нь дээд боловсрол эзэмшигчдийн дунд хүйсийн тэнцвэр алдагдах улмаар гэр бүлийн харьцаа хийгээд угсаатны зүйн хувьд ноцтой хор уршиг учруулж болзошгүй байдлыг бий болгож байна.

Мэдээллийн хүртээмж ба хот хөдөөгийн хүний хөгжлийн ялгаа

2001 оны байдлаар 220 нэрийн сонин, сэтгүүл тогтмол хугацаандаа нэг удаа 1,2 сая хувиар хэвлэгдэж, бие даасан сувагт 4, кабелийн сүлжээний 16 телевиз, 50 телестуди, богино долгионы 14 радио, өргөн долгионы 8 радио, мэдээллийн 11 агентлаг, интернэтийн мэдээллийн 6 сүлжээ үйл ажиллагаагаа явуулж байжээ. Одоо энэ тоо өссөн гэдэг нь дамжиггүй. Гэвч мэдээллийн энэ эх сурвалжуудаар цацагдаж буй мэдээллүүд үнэнд төдий л нийцдэггүй гэхэд буруудахгүй.

Энэ нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн /1992 / хэрэгжилт тааруу, хуулиудад үндэслэлгүй хязгаарлалт, хориглолт, хийдэл байгаагаас гадна үндэсний радио, телевиз, 52 сонин, сэтгүүл засаг төрийн байгууллагын өмчлөлд / эрх мэдэлд/ байгаатай холбоотой.

Мэдээллийн хүртээмжийн хувьд мөнөөх л хөдөөгийн иргэд “хоцрогдож” явна. Үүнд нэг талаас дэд бүтэц хөгжөөгүй байдлыг буруутгаж болох л юм. Шуудан холбоо тогтмол биш, / 7 хоногт 1 удаа МИАТ-ын нислэгтэй/ цахилгаан найдваргүй байнга тасалддаг, радиогийн тэжээлийн хүртээмж муу тохиолдолд ийм байх нь ч аргагүй. Гэвч нөгөө талаас цахилгаан үүсгүүрээр тог авч, цахилгаан гэрэл антенаар телевиз үзэх боломж байвч ингэж чадахгүй байгаад ядуурлыг буруутгая.

Саяхан шинээр дэлгэрч яваа ч маш хүчтэй хэрэглүүр болж буй мэдээллийн эх сурвалж бол яах аргагүй интернэт. Интернэтийг ашиглахад тулгарах нэг том асуудал бол гадаад хэлний мэдлэг. Баярлууштай нь интернэт ертөнцөд бид өөрийн гэсэн орон зайтай болж нэлээдгүй мэдээллийг монгол хэл дээр олж авах бололцоотой болсон. Гэвч одоохондоо монгол хэл дээрх вэбсайт олон биш байна. Ерөнхийдөө интернэтийн гол хэрэглэгчид нь өнөөдөртөө хот суурингийн залуучууд, өсвөр үеийнхэн л байна.

Хот суурингийнханы хувьд мэдээллийн хүртээмж хангалттай гэхэд буруудахгүй бизээ.

Иргэний нийгэм дэх иргэдийн оролцоо, жендэр, мэдээллийн хүртээмжийн байдал өмнөх жилүүдтэй харьцуулбал нэлээд дээшилсэн. Ерөнхийд нь авч үзвэл хот суурин газрын оршин суугчдын хувьд асуудал нэлээд шийдвэрлэгдсэн боловч хөдөөд хоцрогдмол хэвээр байна. Үүнийг тэнцвэржүүлэхэд төрийн бодлого, эдийн засгийн өсөлт, дэд бүтцийн хөгжил чухал ч нөгөө талаас иргэдийн өөрсдийнх нь идэвх, чармайлт, оролцоо хэрэгтэй. Харамсалтай нь аль аль нь одоохондоо бараг алга.